

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хэрэгжилт	Хувь
<b>НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>								
<b>1.1. Хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг харгалзан боловсруулан батлуулж, үүнтэй уялдуулан төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, зарцуулалтын бодлогыг хэрэгжүүлнэ.</b>								
1.1.1	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар боловсруулах, батлуулах /Мандах, Дэлгэрэх, Өргөн сум/	Сумын ОНХС	Хяналт хийж, дүгнэлт гаргасан сумдын тоо	2	3	I-IV улирал	2026 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Дэлгэрэх, Мандах, Өргөн сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулахаар нийт 250.6 сая төгрөгийг төсөвт тусгасантай холбогдуулан ажлын даалгаврыг боловсруулж, ГЗБГЗЗЕГазраар хянуулан батлуулж, тендер зарлуулахаар холбогдох материалыг сумдын ЗДТГазарт хүргүүлсэн. 2026 оны эхний хагас жилийн байдлаар Дэлгэрэх Мандах, Өргөн сумын Засаг даргын Тамгын газраас тендер шалгаруулалтыг зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ба Дэлгэрэх сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэгчээр “Голден мэл” ХХК, Мандах сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэгчээр “Ланд овнер”ХХК, Өргөн сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэгчээр Инженер геодези ХХК шалгарч тус тус гэрээ байгуулан, бэлтгэл ажлын хүрээнд холбогдох байгууллагуудаас мэдээлэл цуглуулах ажил хийгдэж байна.	100

1.1.2.	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажилд хяналт тавих /Сайхандулаан, Замын-Үүд, Сайншанд, Мандах, Дэлгэрэх, Өргөн сум/	Сумын ОНХС	Хяналт хийж, дүгнэлт гаргасан сумдын тоо	3	6	I-IV улирал	Замын-Үүд, Сайншанд зэрэг сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний үе шатуудад хяналт тавьж, холбогдох дүгнэлтийг тус газрын газрын 2026 оны 266 тоот албан бичгээр “Ланд овнер” ХХК болон газар зохион байгуулалт геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлсэн.	100
1.1.3.	“Монгол улсын иргэнд 2026 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж, тайлагнах	-	Газар өмчилсөн иргэдийн тоо	83	283	I-III улирал	Засгийн газрын 2026 оны 46 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд нийт 259 нэгж талбарын 18.23 га газрыг иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэхээр баталснаас 2026 оны 06 дугаар сарын эхний байдлаар 113 нэгж талбарын 8.12 га газрыг аймаг, сумын Засаг даргын шийдвэрээр олгосон. Тогтоолын хэрэгжилт 44.5 хувьтай байна.	100
1.1.4.	Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж, тайлагнах	-	Газар эзэмшсэн иргэдийн тоо	46	281	I-III улирал	Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай Засгийн газрын 2026 оны 45 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд нийт 623 нэгж талбар 172265,56 га газрыг иргэн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулахаар баталснаас 2026 оны 06 дугаар сарын эхний байдлаар 142 нэгж талбарын 1454.31 га газрыг аймаг, сумын Засаг даргын шийдвэрээр олгосон.	100
1.1.5	Сайншанд сумын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах	АОНТХ О-863 сая	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	70-аас багагүй	I-IV улирал	Дорноговь аймгийн Сайншанд сумын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний 09/25 дугаартай зургийн даалгаврыг боловсруулан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай зөвшилцөн аймгийн Засаг даргаар батлуулан аймгийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Уг төндөрийг 2 удаа зарласан боловч шаардлага хангасан аж ахуйн нэгж орж ирээгүй тул дахин зарласан байна.	100

1.1.6	Замын-Үүд сумын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлын зургийн даалгавар, төсвийг боловсруулах, дараа оны төсөвт шаардлагатай төсвийг батлуулах	ОНТХО	Боловсруулсан зургийн даалгавар болон төсөв	1	1	I-IV улирал	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хот хөгжлийн төлөвлөгөөний 10/25 дугаартай зургийн даалгаврыг боловсруулан Хот байгуулалт, барилга , орон сууцжуулалтын яамтай зөвшилцөн аймгийн Засаг даргаар батлуулан 2026.03.12 өдрийн Замын-Үүд сумын ИТХ-ын 02 дугаар тогтоолоор 673 600 00 баталсан. 2026.04.22-ны өдөр зарласан тендерт “Говийн травэл” ХХК орсон бөгөөд тендерийн бичиг баримтын шаардлага хангаагүй дахин 2026.05.18-ны өдөр зарласан бөгөөд 2026.06.08-ны өдөр нээгдэнэ.	100
1.1.7	Сумдын төв суурины хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, батлуулах /Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ, Сайхандулаан, Хөвсгөл, Улаанбадрах, Эрдэнэ сум/	ОНТХО	Ерөнхий төлөвлөгөө баталсан тогтоол	2	8	I-IV улирал	Дорноговь аймгийн Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ, Сайхандулаан, Хөвсгөл, Улаанбадрах, Эрдэнэ сумдын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Циркулпроект ХХК хийж гүйцэтгэн ажиллаж байна.	100
1.1.8.	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, өсөлтийн үр өгөөжийг иргэдийн амьжиргаанд хүртээмжтэй хүргэх талаар авах багц арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайлагнах	-	Тайлангийн тоо	-	2	I-IV улирал	2026 оны 06 дугаар сарын эхний байдлаар 113 нэгж талбарын 8.12 га газрыг аймаг, сумын Засаг даргын шийдвэрээр олгосон. 2026 оны 06-р сарын эхний байдлаар газартай холбоотой нийт 3499 хүсэлтийг цахимаар ирүүлсэн. Үүнээс 2210 нь шинээр газар эзэмших тухай хүсэлт бол 1289 нь өөрийн газар дээр ирүүлсэн хүсэлт байна. Нийт өөрийн газар дээр ирүүлсэн хүсэлтээс 1205 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн бол шийдвэрлэх шатанд 63 хүсэлт байна. Аймгийн хэмжээнд цахим хүсэлтийн шийдвэрлэлт 94.9 хувьтай байна. Мөн 81 иргэн, хуулийн этгээд газрын эрх шилжүүлсний орлогын албан татварын нэхэмжлэхийг цахимаар үүсгэн Qrau ашиглан цахимаар шууд төлсөн.	100

1.2.Иргэн, хуулийн этгээдийн хувийн өмчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулна.								
1.2.1.	Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийг боловсруулахад ГЗБГЗЗЕГ-т санал хүргүүлэх	-	Хүргүүлсэн саналын тоо	-	1	I-IV улирал	Тус газрын 2026.02.27-118, 2026.03.04-ний 131 тоот албан бичгээр сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газарт Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хэлэлцүүлгийг зохион байгуулж, иргэд олон нийтээс санал авах чиглэлийг хүргүүлж, хэлэлцүүлэг зохион байгуулахтай холбоотой мэдээллийг байгууллагын болон сумдын Засаг даргын Тамгын газрын цахим хуудсаар 2 удаа, фэйсбүүк хуудсаар 17 удаагийн пост оруулж, иргэд олон нийтэд хүргэж 31,103 хандалтыг авсан. Мөн 14 суманд танхимын хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлэгт 984 иргэн оролцож, 663 саналыг авч, холбогдох материалыг ГЗБГЗЗЕГ газарт 2026 оны 168 тоот албан бичгээр хүргүүлсэн	100
1.2.2.	Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад ГЗБГЗЗЕГ-т санал хүргүүлэх	-	Хүргүүлсэн саналын тоо	-	1	I-II улирал	Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахтай холбоотой саналыг <a href="http://d.parliament.mn">d.parliament.mn</a> сайтаар илгээсэн.	100
1.2.3.	Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловруулахад ГЗБГЗЗЕГ-т санал хүргүүлэх	-	Хүргүүлсэн саналын тоо	-	1	I-IV улирал	Засгийн газрын албан ёсны платформ ( <a href="https://www.d.parliament.mn">https://www.d.parliament.mn</a> , <a href="https://www.gov.mn">gov.mn</a> )-д байршуулсан салбарын хуулиудын төсөлд санал өгөх арга хэмжээнд байгууллагын 8 албан хаагчдыг бүрэн хамруулсан. Мөн дээрх хуулиудын төсөлд олон нийтээс санал авахаар санал авах холбоосыг байгууллагын цахим болон фэйж хуудсанд байршуулан ажилласан.	100
1.2.4.	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулахад ГЗБГЗЗЕГ-т санал хүргүүлэх	-	Хүргүүлсэн саналын тоо	-	2	I-IV улирал	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төсөлд <a href="http://d.parliament.mn">d.parliament.mn</a> санал илгээсэн.	100

1.2.5.	Засгийн газрын тогтоолын төслийг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, батлуулах	-	Хүргүүлсэн саналын тоо	-	1	I-IV улирал	Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төслийн төсөлд хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх газар эзэмшигч, ашиглагчдаас санал авах ажлын хүрээнд тус газрын 2026.04.02-222, 2026.04.02-ны 223, 2026.04.06-230 тоот албан бичгүүдийг сумдын Засаг даргын тамгын газар, төрийн болон төсөвт 164 байгууллага, уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг 17 аж ахуйн нэгжид хүргүүлэн, хэлэлцүүлэг зохион байгуулахтай холбоотой мэдээллийг байгууллагын болон сумдын Засаг даргын Тамгын газрын цахим хуудсаар 1 удаа, фэйсбүүк хуудсаар 4 удаагийн пост оруулж, иргэд олон нийтэд хүргэж 1353 хандалтыг авсан. Мөн 4 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлэгт 304 иргэн оролцож, цахим хуудас болон харилцаа, холбооны хэрэгслийг ашиглан 291 саналыг өгсөн ба хэлэлцүүлэг, холбогдох саналыг тус газрын 2026 оны албан тоотоор ГЗБГЗЗЕГазарт хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журамд” өөрчлөлт оруулах журмын төсөлтэй танилцан нийт 3 саналыг тус газрын 2026 оны 134 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГазарт хүргүүлсэн.	100
<b>1.3.Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэл, газрын хэвлийн баялаг болон газар дээрх баялгийн бүртгэлийг “блокчейн” технологийг ашиглан гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.</b>								
1.3.1	Газрын тухай хуульд заасны дагуу иргэн, хуулийн этгээдэд олгох газрын	-	Системд бүртгэсэн дуудлага худалдаа,	85	100	I-IV улирал	Сумдын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдаа төсөл сонгон шалгаруулах зарчмаар олгох нийт 144 нэгж талбар	100

	дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг Газрын биржийн цахим системээр зохион байгуулах		төсөл сонгон шалгаруулалтын хувь				тусгагдсанаас 2026 оны 06-р сарын эхний байдлаар 90 нэгж талбарт дуудлага худалдаа 12 нэгж талбарт төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах 11 сумын Засаг даргын шийдвэр гарч зарыг газрын биржийн цахимд 100 хувь бүрэн бүртгэсэн. 2026 оны 06-р сарын эхний байдлаар аймгийн хэмжээнд 58 нэгж талбарт танхимаар 14, цахимаар 44 дуудлага худалдааг зохион байгуулснаас 54 дуудлага худалдаа зохион байгуулагдаж, үүнээс аймаг, орон нутгийн төсөвт нийт 1008.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн.	
1.3.2	Эрх бүхий этгээдийн шийдвэрээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгогдсон нийт нэгж талбарт газрын төлбөр, татварыг Газрын төлбөр, татварын нэгдсэн цахим системээр дамжуулан бүрэн ногдуулах ажлыг зохион байгуулах.	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	95	96	I-IV улирал	Газрын төлбөрийг тооцох боломжтой 15070 нэгж талбарт 5.57 тэрбум төгрөгийн ногдуулалт, 14764 нэгж талбарт 5.71 тэрбум төгрөгийн нэхэмжлэх үүсгэсэн. Газар, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг 11895 нэгж талбарт 20.5 сая төгрөгийн ногдуулалт, 11577 нэгж талбарт 20.46 сая төгрөгийн нэхэмжлэхийг үүсгэж, Татварын системд илгээсэн. Хамрагдалт 97.6 хувьтай байна.	100
<b>1.4.Төрийн өмчийн газрын хяналт, мониторингийг сайжруулж, газрын мониторингийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлнэ.</b>								
1.4.1	Мэргэжлийн байгууллагуудын цахимаар ирүүлсэн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан, дүгнэлтийг хянаж, баталгаажуулах	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100	100	I-IV	2026 оны 05 дугаар сарын 30-ны байдлаар газрын мониторингийн системээр 92 тайлан ирснээс 77 тайланг хянан баталгаажуулж, 7 тайланг алдаа дутагдлыг арилгах талаар зөвлөмж, чиглэл өгч буцаасан бол 8 тайланг хянах шатандаа байна. Захиалгат хянан баталгааны нэгдсэн тайланг тус газрын 2026 оны 379 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.	100
1.4.2	Газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлын үе шатуудад хяналт тавих, эцсийн шатны тайланг	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100	100	III-IV	ОНТХО-2025/19 дугаартай ажил гүйцэтгэх гэрээний дагуу "Инженер геодези" ХХК-ийн гэрээг дүгнэж аймгийн Засаг даргад гэрээ сунгуулахаар тус газрын 2026 оны 177 тоот албан бичгийг хүргүүлж, гэрээг сунгуулсан. Тоон байдлаар ирүүлсэн тайланг хянаж,	100

	хүлээн авахад тоон мэдээллийг гүйцэтгэгч байгууллагаар газрын мониторингийн цахим системд оруулсан эсэхэд хяналт тавьж, газрын мониторингийн мэдээллийн санг бүрдүүлэх						засварыг хийлгэхээр тус газрын 2026 оны 425 тоот албан бичгийг хүргүүлсэн. Мониторингийн системд байршуулах ажил нь системийн хөгжүүлэлттэй хийгдэж байгаа тул хүлээгдэж байна.	
1.4.3	2026 оны бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг үр дүнгээр аймгийн тайланг боловсруулж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх	-	Фото мониторингийн цэгийн тоо	228	228	III-IV	Бэлчээрийн фото мониторингийн ажлын хэсэг, зардлын тооцоог гаргуулахаар тус газрын 2026 оны 255 тоот албан бичгийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэн, ирүүлсэн зардлын судалгааг нэгтгэж, шаардагдах зардлыг шийдвэрлүүлэхээр тус газрын 2026 оны 435 тоот албан бичгийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.	100
1.4.4.	Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын үр дүнгээр газар ашиглалтын зөрчил, хохирол, бохирдолд өртсөн газрын судалгааг гаргаж, хохирол, бохирдлыг арилгах хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	50	100	I-IV	2026 онд газрын мониторингийн системээр 92 тайлан ирснийг хянаж баталгаажуулснаас газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын үр дүнгээр бохирдол, доройтолд өртсөн газрууд байхгүй, харин зөвшөөрөлтэй газрын хэмжээнээс илүү ашиглаж, талбайн хэмжээг сунгасан 14 иргэн, аж ахуйн нэгжид хашаагаа татах талаар мэдэгдэл хүргүүлсэн.	100
1.4.5.	2020-2024 оны бэлчээрийн фото мониторингийн ажлын үр дүнг засварлан сайжруулсан мэдээллийг газрын мониторингийн цахим системд оруулах	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100	100	I-II улирал	2020-2024 оны бэлчээрийн фото мониторингийн ажлын үр дүнг засварлан сайжруулсан 2020-2022 оны 44 цэгийн мэдээллийг газрын мониторингийн цахим системд засварлаж, тус газрын 2026 оны 315 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.	100

1.5.Маш хүчтэй доройтсон газрын ашиглалтыг нэгдмэл сангийн ангиллаар тодорхойлох, нөхөн сэргээнэ.								
1.5.1	Газрын доройтлыг тодорхойлох аргачлалын дагуу нэгдмэл сангийн ангилал тус бүрээс маш хүчтэй доройтолд өртсөн талбай болон нөхөн сэргээх байршлуудыг тодорхойлж, газар хамгаалах нөхөн сэргээх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх	-	Төлөвлөгөө -ний тоо	-	1	I-II	Аймгийн хэмжээнд 2025 онд хийгдсэн хот тосгон бусад суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын хөрсний лабораторийн шинжилгээгээр 38 цэгт хүнд металлын хүлцэх хэмжээнээс давсан, 51 цэгт эрүүл ахуйн бага болон дунд бохирдолд өртсөн талбай бүртгэгдсэн. Бохирдолд өртсөн цэгүүдэд хамгаалах арга хэмжээг 2027 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгахаар боловсруулалтын ажил хийгдэж байна.	100
1.5.2.	Газар хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100	100	III-IV	Бэлчээрийн фотомониторингийн 2025 оны судалгааны үр дүнг үндэслэн Сайхандулаан суманд 85316 га газрыг сэлгэн ашиглахаар сумын газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөөнд тусгасан. Арга хэмжээг 6-9 сарын хугацаанд хэрэгжүүлнэ.	100
1.5.3.	Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын үр дүнгээр газар ашиглалтын зөрчил, хохирол, бохирдолд өртсөн газрын судалгааг гаргаж, хохирол, бохирдлыг арилгах хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх	Үйл ажил лагаа	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	50	100	I-IV	2026 оны 06 дугаар сарын эхний байдлаар газрын мониторингийн системээр хянаж баталгаажуулсан 92 тайлангийн үр дүнгээр бохирдол, доройтолд өртсөн газрууд байхгүй, харин зөвшөөрөлтэй газрын хэмжээнээс илүү ашиглаж, талбайн хэмжээг сунгасан 14 иргэн, аж ахуйн нэгжид хашаагаа татах талаар мэдэгдэл хүргүүлсэн.	100
1.5.4.	Агаар, сансрын зураг ашиглан эвдрэлд орсон газрын судалгааг хийж, зураглах, мэдээллийн сан байгуулах, газрын доройтлыг бууруулах арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг агентлагт хүргүүлэх	Үйл ажил лагаа	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	100	I-IV	Агаар, сансрын зураг ашиглан эвдрэлд орсон газрын судалгааг хийж, зураглах ажлыг аймгийн хэмжээнд гүйцэтгэж нийт 267 байршилд 459 га эвдэрсэн газрыг газарзүйн мэдээллийн системд бүртгэж тус газрын 2026 оны 407 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.	100

1.6.Олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтцийг Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулна.								
1.6.1.	Дэлхийн геодезийн сүлжээнд тулгуурласан Монгол Улсын геодезийн сүлжээг сайжруулах төлөвлөгөө боловсруулахад санал өгөх	-	Санал өгсөн төлөвлөгөө ний тоо	1	1	I-IV	GNSS байнгын ажиллагаатай станцын сүлжээг өргөжүүлэх. Аймаг, бүсийн төвүүдэд шинэ суурин станц байгуулах. Одоо ажиллаж буй станцуудын тоног төхөөрөмжийг шинэчлэх, найдвартай ажиллагааг хангах.	100
1.6.2.	GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах	-	Байнгын ажиллагаа тай станцын тоо	2	2	I-IV	Нутаг дэвсгэрт хамаарч буй навигацийн хиймэл дагуулын байршил тодорхойлох (GNSS) байнгын ажиллагаатай станцыг Монгол Улсын тулгуур сүлжээний дээд ангийн цэг тэмдэгтийн хэмжилтийн нөхцөлийг алдагдуулахгүй хадгалан хамгаалах, тухайн сум суурин газарт хийгдэх геодезийн хэмжилт зураглалын ажлын бодит агшны засвар (RTK) дамжуулалтыг хангуулах, бүс нутгийн газар хөдлөлт, геодинамикийн шилжилт хөдөлгөөний судалгаанд ашиглах ач холбогдолтой нөлөөллийн судалгааг хавсралтад заасан зааврын дагуу чанартай, бүрэн гүйцэтгэж ажиллаж байна.	100
1.6.3.	Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлын үр дүнг цахим системд хянаж баталгаажуулах	Орон нутгийн төсөв	Үр дүнг цахим системд хянаж, баталгаажуулсан эсэх	Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн дэд системийг 2025 онд хөгжүүлсэн.	Үр дүнг цахим системд хянаж, баталгаажуулна	III-IV	Геодези, зураг зүйн үйл ажиллагааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.2-т заасан бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд нутаг дэвсгэртээ хамаарах байр зүйн зураг, зураг зүйн бүтээлд тусгагдах газар зүйн нэр, хил, шинээр байгуулагдсан болон өөрчлөгдсөн объектын талаарх мэдээлэл, геодезийн байнгын цэг, тэмдэгтийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, жил бүр тооллого явуулж дүнг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдээлэх ажлын чиглэлийг сумдын Засаг дарга нарт 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдөр хүргүүлсэн. Одоогийн байдлаар Дэлгэрэх, Сайншанд сумдын нутаг дэвсгэрт байрлах нийт 33 геодезийн байнгын цэг, тэмдэгтийг geodesy.gov.mn системд бүртгүүлэн ажиллаж байна.	100

1.6.4.	Өргөн суманд геодезийн утсан цэг тэмдэгт сэргээх ажил	СОНХС-17,2 сая	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	I-IV	2026 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Өргөн суманд геодези утсан цэг тэмдэгт сэргээх 17.2 сая төгрөгийг төсөвт тусгасантай холбогдуулан ажлын даалгаврыг боловсруулж, ГЗБГЗЗЕГазраар хянуулан батлуулж, тендер зарлуулахаар холбогдох материалыг сумдын ЗДТГазарт хүргүүлсэн. 2026 оны эхний хагас жилийн байдлаар Өргөн сумын Засаг даргын Тамгын газраас тендер шалгаруулалтыг зарлаж, гүйцэтгэгчээр Талст газар ХХК шалгарч гэрээ байгуулан 8 цэгийн суулгалтын ажил хийгдэж байна.	100
<b>1.7.Монгол орны газар нутгийг бодит агшны мэдээлэл бүхий байр зүйн тоон зургаар зурагжуулж, хэрэглэгчдэд шуурхай хүргэж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн байр зүйн болон баталгаажсан нэг маягийн суурьтай сэдэвчилсэн газрын зураг, атласаар хангана.</b>								
1.7.1	Хяналт, шалгалтаар илэрсэн алдаатай газрын зургийн зөрчлийг арилгуулах арга хэмжээг зохион байгуулах	-	Арга хэмжээний тоо	-	2	I-IV	Хяналт шалгалтаар илэрсэн алдаатай зөрчил болох газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүртгэх, талбайн хэмжээ засварлах, байршлын хувьд зөрүүтэй мөн иргэн хуулийн этгээдийн бүртгэл зөрүүтэй нийт 263 нэгж талбарт өөрчлөлт оруулсан.	100
<b>1.8.Гурав ба дөрвөн хэмжээст газрын кадастрын нэгдсэн системийг бий болгож хөгжүүлнэ.</b>								
1.8.1.	Хот байгуулалтын кадастрын цахим системд барилга, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн мэдээллийг бүртгэх ажлыг зохион байгуулах	-	Төлөвлөлтийн давхаргын мэдээллийн тоо	2025 онд программ хөгжүүлэлт хийгдсэн.	8 давхаргын мэдээлэл бүртгэнэ.	I-IV	Тайлант оны эхний хагас жил хот байгуулалтын кадастрын цахим системээр шинээр баригдсан 6 барилга, нөхөн бүрдүүлэлтээр 12 барилга байгууламжийг бүртгэн оруулсан.	100
1.8.2.	Барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын	-	Өгөгдөл мэдээллийн тоо	2025 онд программ хөгжүүлэлтийн	45 давхаргын өгөгдөл, мэдээлэл бүртгэнэ.	I-IV	Тайлант оны эхний хагас жил хот байгуулалтын кадастрын цахим системээр дэд бүтцийн инженерийн шугам сүлжээнд Зүүнбаян дэд станцаас Хамарын хийдийн 3 зам хүртэлх 19995м агаарын шугам, цэвэр усны шугам 1200м, ариутгах татуургын 600м шугам тус тус бүртгэсэн байна.	100

	сүлжээний өгөгдөл, мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулах			ажил хийгдсэн.				
<b>1.9.Улсын хэмжээнд гурван хэмжээст байр зүйн болон газар доорх инженерийн шугам сүлжээний зургийг зохионо.</b>								
1.9.1.	Сайншанд хотын суурьшлын бүсийн 1:1000 масштабтай байр зүйн зураг, газрын доорх шугам сүлжээний зургийн солбилцлын ITRF 2020 эринд шилжүүлэх ажлыг эхлүүлэх	АОНТХ О-576,09 сая	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	100	I-IV	2026 онд дээрх ажлыг хийж гүйцэтгэхээр орон нутгийн төсөвт 576.09 сая төгрөгийг төсөвт тусгасантай холбогдуулан ажлын даалгаврыг боловсруулж, ГЗБГЗЗЕГазраар хянуулан батлуулж, тендер зарлуулахаар холбогдох материалыг аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас тендер шалгаруулалтыг зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ба тус ажлын гүйцэтгэгчээр Геосүрвэй ХХК шалгарч гэрээ байгуулсан.	100
1.9.2	Замын-Үүд сумын суурьшлын бүсийн 1:1000 масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF 2020 эринд шилжүүлэх ажлыг эхлүүлэх	СОНХС-266,05 сая	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	100	I-IV	2026 онд дээрх ажлыг хийж гүйцэтгэхээр орон нутгийн төсөвт 266.05 сая төгрөгийг төсөвт тусгасантай холбогдуулан ажлын даалгаврыг боловсруулж, ГЗБГЗЗЕГазраар хянуулан батлуулж, тендер зарлуулахаар холбогдох материалыг Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Замын-Үүд сумын ЗДТГазраас тендер шалгаруулалтыг зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ба тус ажлын гүйцэтгэгчээр Эко лөнд менежмент ХХК шалгарч гэрээ байгуулсан.	100
<b>1.10. Орон зайн бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтын оновчтой, үр ашигтай байдлыг нэмэгдүүлнэ.</b>								
1.10.1.	Монгол Улсад Үндэсний Орон зайн өгөгдлийн дэд бүтэц	-	Судалгааны тоо	-	1	I-IV улирал	Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой албан бичиг ГЗБГЗЗЕГазраас ирээгүй.	100

	байгуулах, нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлэх стратеги, төлөвлөгөөг боловсруулж, батлах		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой албан бичиг ГЗБГЗЗЕГазраас ирээгүй.	-
1.10.2.	Төрийн болон бусад байгууллагуудыг орон зайн суурь мэдээллээр ханган ажиллах боломжийг бүрдүүлэх, солилцох ажлыг зохион байгуулах	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	80	90	I-IV улирал	Хатанбулаг сумын суурьшлын бүсийн шинэчлэгдсэн байр зүйн зураг бэлэн болсон. ITRF2020-д нийцсэн координатын бааз бий болсон. Хот байгуулалт, зураг төсөл, инженерийн шугам сүлжээний ажилд ашиглах боломжтой. Цаашдын дижитал газрын мэдээллийн суурь болж өгсөн.	100
1.10.3.	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геоортал цахим системд нэмэлт хөгжүүлэлтийг хийж, хэвийн үйл ажиллагааг хангах	-	Нэмэлт хөгжүүлэлтийн тоо	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геоортал цахим системийн 2.0 хувилбарыг 2024 онд хэрэглээнд нэвт рүүлсэн	1	I-IV улирал	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геоортал цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийгдээгүй байна.	100

ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ								
2.1. Газрын нэгдмэл санг эрхлэх, Газрын нэгдмэл сангийн цахим системийг хөгжүүлэх								
2.1.1	Байгаль орчны төлөв байдлын БОХ-1.1, БОХ-1.2 тайлан, газрын нэгдмэл сангийн 2025 оны аймгийн тайланг ГЗБГЗЗЕГ хүргүүлэх	-	Тайлангийн тоо	1	Газрын нэгдмэл сангийн 2025 оны аймгийн нэгдсэн тайлан, БОХ-1.1, БОХ-1.2, ГНСТ-1, ГНСТ-2, ГНСТ-4, бусад тайлан мэдээ болон эрх бүхий этгээдийн шийдвэр (захирамж) -ийн мэдээг бэлтгэж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн	I улирал	Засгийн газрын 2022 оны 432 дугаар тогтоолоор батлагдсан "Газрын нэгдмэл сангийн тайлан эрхлэх журам"-д заасны дагуу аймгийн нэгдмэл сангийн 2025 оны аймгийн нэгдсэн тайлан, БОХ-1.1, БОХ-1.2, ГНСТ-1, ГНСТ-2, ГНСТ-4, бусад тайлан мэдээ болон эрх бүхий этгээдийн шийдвэрийн мэдээг нэгтгэн гаргаж ГЗБГЗЗЕГ азарт 2026 оны 01-р сарын 15-ны дотор хүргүүлсэн.	100
2.2. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, газрын харилцааны салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах								
2.2.1.	Аймгийн хэмжээнд газар, геодези, зураг зүйн чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх, эрсдэлийн түвшин бууруулж, улсын байцаагийн гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулах	-	Объектын хамрагдалтын хувь	100	100	I-IV улирал	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 115 дугаар тогтоолоор 2026 оны төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг цуцлах шийдвэр гарсантай холбогдуулан хяналт шалгалт хийгдэх боломжгүй болсон.	100

2.2.2.	Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын хэрэгжилт хангуулах, хяналт шалгалт хийх	-	Хамрагдсан сумын тоо	-	14	I-IV улирал	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 115 дугаар тогтоолоор 2026 оны төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг цуцлах шийдвэр гарсантай холбогдуулан хяналт шалгалт хийгдэх боломжгүй болсон.	100
2.2.3.	Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	-	Өргөдөл шийдвэрлэсэн хувь	85	90	I-IV улирал	Тайлангийн хугацаанд нийт 47 өргөдөл, хүсэлт, 12 албан бичиг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. 2 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж байна. Шалгалт үргэлжилж байгаа. Нийт өргөдлийн 43,4 хувь нь зөрчлийн хуулиар арга хэмжээ авхуулах тухай хүсэлт эзэлж байна.	100
2.2.4.	Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авах	-	Хэрэгжилтийн хувь	100	100	I-IV улирал	Зөрчлийн талаарх гомдол мэдээлэл нийт 46 бүртгэж, хялбаршуулсан журмаар 46 шийдвэрлэн нийт 40'500'000 төгрөгийн шийтгэл оногдуулж 74 хувь нь төлөгдөөд байгаа бөгөөд үлдсэн хувь нь хугацаа болоогүй байна. Зөрчилтэй холбоотой нөхөн төлбөр 33'885'708 төгрөгийг ногдуулж, бүрэн барагдуулаад байна.	100
2.2.5.	Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах, дүгнэлт гаргаж хүргүүлэх ажлыг зохион байгуулах	-	Шийдвэрлэлтийн хувь	100	100	I-IV улирал	2026 оны 06-р сарын эхний байдлаар Дорноговь аймаг дахь сум дундын анхан шатны шүүхээс ирүүлсэн шийдвэрийн дагуу 1 иргэний хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргаж, тус газрын 2026 оны 162 тоот албан бичгээр хүргүүлсэн.	100
2.2.6	Төрийн болон албаны нууцын үйл ажиллагааг зохион байгуулах	-	Хэрэгжилтийн хувь	96	98	I-IV улирал	Төрийн болон албаны нууцын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. 2026 онд шилжин томилогдсон 1 албан хаагчаас төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгаа гаргуулсан авсан.	100

2.2.7	Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах	-	Шийдвэрлэлт -ийн хувь	-	100	I-IV улирал	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 115 дугаар тогтоолоор 2026 оны төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг цуцлах шийдвэр гарсантай холбогдуулан хяналт шалгалт хийгдэх боломжгүй болсон.	100
2.2.8	Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэн явуулах мэргэжлийн байгууллагад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах		Шийдвэрлэлт -ийн хувь	-	100	I-IV улирал	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 115 дугаар тогтоолоор 2026 оны төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг цуцлах шийдвэр гарсантай холбогдуулан хяналт шалгалт хийгдэх боломжгүй болсон.	100
2.2.9	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан газарт дүгнэлт гаргах, гэрээ байгуулах, төлөвлөгөө боловсруулах жишиг ажлын даалгаврыг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах		Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100	100	I-IV улирал	2026 оны эхний хагас жилийн байдлаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан газарт дүгнэлт гаргах, гэрээ байгуулахтай холбоотой холбогдох байгууллагуудаас ирүүлсэн албан тоот байхгүй.	100
<b>ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>								
3.1.	“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	92	95	I-IV улирал	Газрын даргын 2026 оны А/25 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан. Төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг гарган нэгтгэж, тус газрын 460 тоот албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлсэн.	100

3.2.	Албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	95	100	I-IV улирал	Газрын даргын 2026 оны А/21 дүгээр тушаалаар "Төрийн албан хаагчийн сургалт, хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-г батлан хэрэгжүүлж, албан хаагчдыг сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд хамруулах ажлыг зохион байгуулсан. Төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг гарган нэгтгэж, тус газрын 460 тоот албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлсэн.	100
3.3.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнах	-	Хэрэгжилтийн хувь	85	90	I-IV улирал	Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөөг боловсруулж, газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2025 оны хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах 5 албан хаагчдад ХАСХОМ гаргах зөвлөмжийг тухай бүр өгч ажиллан, мэдүүлгийг хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч, баталгаажуулсан. 2026 оны 06-р сарын байдлаар ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргасан албан тушаалтан байхгүй. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой 2 удаагийн танхимын сургалтыг байгууллагын албан хаагчдад хийж, зөвлөмж чиглэлийг өгч ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жилийн байдлаар гаргаж тус газрын 2026 оны 436 албан тоотор хүргүүлсэн.	100
3.4.	"Ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх" зорилтот жилийн хүрээнд салбарын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	-	Хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	"Ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх" зорилтот жилийн хүрээнд салбарын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, албан хаагчдын ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэх сургалт, зөвлөмж, мэдээллийн ажлуудыг зохион байгуулан ажилласан. Мөн ёс зүйн зөвлөмж, уриалга бүхий мэдээллийг тогтмол хүргэж, албан хаагчдын хариуцлага, ёс зүйн ухамсрыг төлөвшүүлэх чиглэлээр ажилласан.	100

							Төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулж, тус газрын 429 дүгээр албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлсэн.	
3.5.	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулж, тогтвортой хэрэгжүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	92	95	I-IV улирал	<p>2026 онд нийт 1244928,7 мянган төгрөгийн төсөв батлагдсан. Үүнээс хагас жилийн байдлаар урсгал үйл ажиллагааны зардалд 463446,4 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Үүнээс улсын төсвөөс 427302,7 мянган төгрөг, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 36143,7 мянган төгрөгийн санхүүжилтээс бүрдэж байна.</p> <p>Байгууллагын тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдахад зардалд нийт 408536,5 мянган төгрөгийн зардлыг зарцуулж 54909,8 мянган төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна. Нийт гарсан зардлыг задаргаагаар нь ангилбал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардалд 346348,4 мянган төгрөг,</li> <li>2. Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 42790,2 мянган төгрөг</li> <li>3. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 9638,1 мянган төгрөг</li> <li>4. Хангамж бараа материалын зардалд 1625,7 мянган төгрөг</li> <li>5. Бараа үйлчилгээний бусад зардалд 8134,0 мянган төгрөгийн зардлыг тус тус зарцуулсан.</li> </ol> <p>Мөн олгогдсон төсөв санхүүжилтийн дагуу зардлыг зарцуулж өр авлага үүсгэлгүй ажиллаж байгаа бөгөөд албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл хоол унааны зардлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу 100% бодож тогтмол хийгдэж байгаа болно. Мөн Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 12-р сарын 10-ны өдрийн 05 тоот “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгаврын дагуу батлагдсан төсвийг зарцуулж хэтэрсэн үр ашиггүй зарцуулсан зардал гараагүй ажиллаж байна.</p>	100

3.6.	“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах	-	Тарьсан мод, сөөгний тоо	100	100	II, IV улирал	Сайншанд сумын 4-р багийн Говь парк цэцэрлэгт хүрээлэнд 2026 оны 05-р сарын 11-ны өдөр 154 ширхэг хайлаас модыг тарьж суулгасан. Аймгийн Засаг даргын 2025 оны “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх тухай 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг гарган тус газрын 2026 оны 237 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад хүргүүлсэн.	100
3.7.	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	-	Төлөвлөгөө -ний хэрэгжилтийн хувь	80	100	I-IV улирал	2026 оны хагас жилийн байдлаар албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан 8 арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. Нийт 678 албан бичиг хүлээн авч бүртгэн, холбогдох албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж ажилласан. Мөн 435 албан бичгийг стандартын дагуу боловсруулан холбогдох байгууллага, иргэдэд хүргүүлж ажилласан. Аймгийн архивын газраас байгууллагын нийт 27 албан хаагчид сургалт авч зохион байгуулан ажилласан.	100
3.8.	Байгууллагын архивын ажлын 2026 оны төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	-	Төлөвлөгөө -ний хэрэгжилтийн хувь	80	100	I-IV улирал	2026 оны архивын төлөвлөгөөг 8 заалттайгаар гарган Газрын даргаар батлуулж хэрэгжилтийг гарган ажилласан.	100
3.9.	Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангах	-	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн хувь	92	96	I-IV улирал	Хуулийн хэрэгжилтийн хүрээнд цахим хуудсанд нээлттэй байхаар заасан 5 төрлийн 87 заалтын мэдээллийг тухай бүр шинэчлэн, <a href="http://www.shilen.gov.mn">www.shilen.gov.mn</a> цахим системд байршуулсан.	100
3.10.	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулж, нэгтгэн тайлагнах	-	Хугацаандаа тайлагнасан эсэх	Хугацаанд нь тайлагнасан.	Хугацаанд нь тайлагнана.	I-IV улирал	2026 оны эхний хагас жилийн байдлаар Аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын "Тогтвортой бодлого-Тасралтгүй хөгжил"	100

							2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах" зорилтот хөтөлбөр (2023-2026), "Цахим Дорноговь" зорилтот хөтөлбөр (2023-2026), Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах ажлыг холбогдох нэгж, мэргэжилтнүүдэд хуваарилан хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн тайлан мэдээг нэгтгэн боловсруулж, холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.	
3.11.	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж тайлагнах	-	Хугацаандаа тайлагнасан эсэх	Хугацаанд нь тайлагнасан.	Хугацаанд нь тайлагнана.	I-IV улирал	2026 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг шийдвэрийн байгууллагад холбогдох заалтуудын хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тайлагнах хугацаа нээсэн тухай бүр <u>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний цахим систем</u> сайтад нэгтгэн тайлагнаж, тайлан мэдээг цаасан хэлбэрээр аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажиллаж байна.	100

ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ								
4.1.Газрын мониторингийн цахим системд зайнаас тандан судлалын арга зүйг нэвтрүүлсэн модуль хөгжүүлэх								
4.1.1	Газрын мониторингийн цахим системд сумын төвүүдэд хийгдсэн дроноос авсан агаарын зургийг оруулж, баяжуулах	-	Мэдээллийн санд оруулсан зургийн тоо	-	2	I-II улирал	ОНТХО-2025/19 тоот гэрээт ажлын албан даалгаварт тусгагдсаны дагуу 14 сум, бусад суурины газарт ортофото зураг авах шаардлагыг тус газрын 2026 оны 425 тоот албан бичгээр Инженер геодези ХХК-д хүргүүлсэн. Дээрх зургийг гүйцэтгэгчээс хүлээн авснаар цахим системд оруулах боломжтой.	100
4.1.2.	Газрын мониторингийн цахим системд нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хэрэглээнд нэвтрүүлэхэд орон нутгийн зүгээс шаардлагатай арга хэмжээг авах	-	Хөгжүүлэлтийн тоо	1	1	I-IV улирал	Газрын мониторингийн цахим системд нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хэрэглээнд нэвтрүүлэхэд орон нутгийн зүгээс шаардлагатай дараах арга хэмжээг авч ажилласан. <ul style="list-style-type: none"> <li>- Хиймэл дагуулын мэдээ ашиглан эвдэрсэн газрын бүртгэлийг аймгийн хэмжээнд нэгтгэн гаргаж тоон байдлаар ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.</li> <li>- 2010-2024 онуудад хийгдсэн төлөвлөгөөт хянан баталгааны тайлан мэдээг тоон байдлаар хүргүүлсэн.</li> <li>- Хиймэл дагуулын мэдээг ашиглаж бэлчээрийн газрын ургац, доройтлын индексийг тодорхойлсон 2025, 2026 оны төлөв байдлыг зургийг боловсруулсан.</li> <li>- Системийн хөгжүүлэлтэд гарч буй алдаа, түүнийг сайжруулахтай холбоотой талаарх 2 саналыг 2026 оны 04-р сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан танхимын сургалтаар өгсөн.</li> </ul>	100
4.2 .Газар, геодези, зураг зүйн хяналт шалгалтын нэгдсэн систем хэрэглээнд нэвтрүүлэх								
4.2.1.	Газрын харилцааны салбарын хяналт шалгалтын нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлж хэвийн үйл ажиллагааг хангах.	-	Системийг хэрэглээнд нэвтрүүлсэн сумын тоо	-	14	I-IV улирал	ГЗБГЗЗЕГ-аас боловсруулж буй “Газар, геодези, зураг зүйн хяналт шалгалтын цахим систем”-ийн хөгжүүлэлт бүрэн дуусаагүй бөгөөд системийн сайжруулалттай холбоотой саналыг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд тус систем хэрэглээнд бүрэн нэвтрээгүй байна.	100

4.2.2.	Газрын мониторингийн цахим системд сумын төвүүдэд хийгдсэн дроноос авч, боловсруулалт хийгдсэн агаарын зургийг оруулж, баяжуулах	Үйл ажиллагаа	Мэдээллийн санд оруулсан сумын тоо	2	1	I-IV улирал	ОНТХО-2025/19 тоот гэрээт ажлын албан даалгаварт тусгагдсаны дагуу 14 сум, бусад суурины газарт ортофото зураг авах шаардлагыг тус газрын 2026 оны 425 тоот албан бичгээр Инженер геодези ХХК-д хүргүүлсэн. Дээрх зургийг гүйцэтгэгчээс хүлээн авснаар цахим системд оруулах боломжтой.	100
<b>4.3. Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх замаар салбарын хэмжээнд цахим шилжилт хийх үйл ажиллагааг дэмжих</b>								
4.3.1.	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-д гарч буй цахим үйлчилгээг нэмэх, үйлчилгээний чанарыг сайжруулах	-	“E-Mongolia”-д холбосон газрын харилцааны салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо	11	19	I-IV улирал	Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг хэрэгжүүлэх хүрээнд газрын мэдээллийн санг E-Mongolia системтэй уялдуулан ажиллаж, иргэдэд газрын лавлагаа, мэдээллийг цахимаар авах боломжийг бүрдүүлж иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэж, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.	100
4.3.2.	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем болон салбарын бусад цахим системүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, гарсан доголдлыг тухай бүр засварлах	-	Хэвийн үйл ажиллагааг хангасан эсэх	Хэвийн үйл ажиллагааг Хангасан.	Хэвийн үйл ажиллагааг Хангасан	I-IV улирал	Салбарын үйл ажиллагаанд ашиглагдаж буй ArcGIS программд доголдол гарч 5 сумын газрын даамалд уг программыг шинээр суулган хэвийн ажиллагааг хангасан.	100
4.3.3.	Салбарын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа болон шинээр хэрэглээнд нэвтрүүлэх системүүдийн нэмэлт хөгжүүлэлт хийх, хэрэглээнд нэвтрүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах	-	Хэвийн үйл ажиллагааг хангасан эсэх	Хэвийн үйл ажиллагааг Хангасан.	Хэвийн үйл ажиллагааг Хангана	I-IV улирал	Салбарын үйл ажиллагаанд ашиглагдаж буй QGIS программд нэмэлт хөгжүүлэлт хийгдсэнтэй холбогдуулан Газрын удирдлагын хэлтсийн 5 албан хаагч болон сумдын газрын даамлуудын 11 компьютерт программ хангамжийн шинэчлэл хийж, хэвийн үйл ажиллагааг хангасан.	100

4.3.4.	Газар өмчлөх, эзэмших, ашиглах, эрхтэй холбоотой иргэн, хуулийн этгээдийн 27 төрлийн хүсэлтийг цахимаар авч шуурхай шийдвэрлэх	-	Шийдвэрлэлт ийн дундаж хоног	30-60	5-10	I-IV улирал	2026 оны 06-р сарын эхний байдлаар газартай холбоотой нийт 3499 хүсэлтийг цахимаар ирүүлсэн. Үүнээс 2210 нь шинээр газар эзэмших тухай хүсэлт бол 1289 нь өөрийн газар дээр ирүүлсэн хүсэлт байна. Нийт өөрийн газар дээр ирүүлсэн хүсэлтээс 1205 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн бол шийдвэрлэх шатанд 63 хүсэлт байна. Аймгийн хэмжээнд цахим хүсэлтийн шийдвэрлэлт 94.9 хувьтай байгаа бол шийдвэрлэлтийн дундаж хоног 16 байна.	100
4.3.5.	Иргэн, хуулийн этгээдийн газрын эрх шилжүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгож, албан татварыг цахимаар шуурхай төлөх боломжийг бүрдүүлэх	-	Цахимжуул сан хувь	-	100	I-II улирал	ГЗБГЗЗЕГаараас "Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх" үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, орлогын албан татварыг цахимаар төлөх боломжийг бүрдүүлэн нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэн 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн хэрэглээнд нэвтрүүлсэн. Уг нэмэлт хөгжүүлэлтийн хүрээнд нийт 81 иргэн, хуулийн этгээд газрын эрх шилжүүлсний орлогын албан татварын нэхэмжлэхийг цахимаар үүсгэн Qraу ашиглан цахимаар шууд төлсөн.	100
4.3.6.	Хот байгуулалтын кадастрын нэгдсэн системийн 20 гаруй үйлчилгээг цахимжуулж, төрийн байгууллагуудын мэдээллийн сантай холбож, иргэн, хуулийн этгээд цахимаар үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх	-	Дундын мэдээллийн сангийн тоо	2	1	I-IV улирал	Тайлант оны эхний хагас жил хот байгуулалтын кадастрын цахим системээр нийт 116 цахим хүсэлт ирсэн бөгөөд тус хүсэлтийг 100% шийдвэрлэсэн.	100
4.3.7.	Байгууллагын дата төвийн мэдээллийн аюулгүй байдлыг	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100	100	I-IV улирал	Байгууллагын серверийн хэвийн, тасралтгүй ажиллагааг хангах үүднээс цахилгааны хэлбэлзэл, тасалдлаас үүдэн	100

	хангах, арга хэмжээг зохион байгуулах						гарах эрсдэлээс хамгаалж тог баригч суурилуулсан. Мөн вирусийн программ суулган, USB болон бусад зөөврийн төхөөрөмжийг зөвшөөрөлгүй холбогдохоос урьдчилан сэргийлж хамгаалалтын функцуудыг бүрэн идэвхжүүлсэн.	
4.3.8.	Байгууллагын дата төвийн техник, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, ашиглагдаж буй программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах	-	Хэвийн үйл ажиллагааг хангасан эсэх	Хэвийн үйл ажиллагааг хангасан	Хэвийн үйл ажиллагааг хангана	I-IV улирал	ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/183 дугаар тушаалаар батлагдсан журмыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна. Байгууллагад ашиглагдаж буй нийт 73 техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор 98 удаагийн засвар, үйлчилгээ хийж гүйцэтгэсэн. Мөн программ хангамжийн ашиглалт, хэвийн ажиллагааг хангах хүрээнд 105 удаагийн нийт 203 удаагийн тасралтгүй, найдвартай ажиллагааг үзүүлэн ажилласан.	100
4.3.9.	Архивын цахим системээр үйлчилгээ үзүүлэх	-	Үйлчилгээ үзүүлсэн хувь	-	100	I-IV улирал	Дотоод албан хэрэгцээнд 18 хадгаламжийн нэгжийг ашиглуулан бүртгэл хөтөлсөн, цахимаар газрын даргын Б тушаал, Аймгийн Засаг даргын захирамж, Сумдын Засаг даргын захирамж, Зөрчил хянан шийдвэрлэх материал, Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол зэрэг материалаар 37 лавлагааг албан хаагчдад хүргэж, Мөн архивын цахим систем засвартай байх үед цахимжуулж хадгалсан материалаасаа олгосон ажилласан.	100
4.3.10.	Тоон гарын үсгийн олголт хийх, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглахад арга зүйн зөвлөгөөгөөр хангах	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	95	100	I-IV улирал	2026 оны 4 сарын 21-ний өдөр ГЗБГЗЗЕГ-аас тоон гарын үсгийн ашиглалтын талаар сургалт орсон бөгөөд албан хаагчдад тоон гарын үсэг ашиглах заавар зөвлөмжийг тухай бүр өгч үүний үр дүнд албан бичиг, тайлан, өргөдөл, гэрээ, egazar, tender.gov.mn, emongolia зэрэг системүүдэд саадгүй нэвтрэн өдөр тутамдаа ашиглаж байна. Тус байгууллагын хэмжээнд 1 тоон гарын үсэг ашиглаж байна.	100

4.3.11.	Байгууллагын тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг хангах	Үйл ажил лагаа, урсгал төсөв	Хэвийн үйл ажиллагааг хангасан хувь	100	100	I-IV улирал	Мэдээлэл дамжуулах сүлжээний кабель, холболтыг шалгаж, гэмтэл гарсан тохиолдолд шуурхай засварлаж найдвартай ажиллагааг 100 хувь ханган ажиллаж байна. Байгууллагын хэмжээнд нийт 15 удаагийн сүлжээний доголдол гарснаас сумдын газрын даамлуудын VPN холболтын алдаа 12 байв.	100
4.3.12.	Байгууллагын дотоод болон салбарын мэдээллийн аюулгүй байдлыг хангах хорт код эсэргүүцэгч программ хангамжийн хэвийн ажиллагааг хангах	-	Хэрэгжилт ийн хувь	85	90	I-IV улирал	Байгууллагын мэдээллийн систем, сүлжээ болон техник хэрэгслүүдийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор <b>Kaspersky Endpoint Security, kaspersky Plus</b> зэрэг хамгаалалтын лицензтэй программ хангамжийг нийт албан хаагчдын компьютерт суурилуулж, USB болон бусад зөөврийн төхөөрөмжийг зөвшөөрөлгүй холбогдохоос урьдчилан сэргийлэх, шаардлагатай хамгаалалтын функцуудыг бүрэн идэвхжүүлсэн. Программын лицензийн хугацаа 2027 оны 3 дугаар сард дуусна.	100
<b>4.4. Газрын зөрчил маргааныг бууруулна.</b>								
4.4.1.	Газрын зөрчил, маргаантай холбоотой асуудлыг шийдвэрлэх, холбогдох арга хэмжээг зохион байгуулах	-	Буруулсан хувь	-	5	I-IV улирал	Газрыг зориулалтын дагуу ашиглаагүй, талбайн хэмжээг илүү ашигласан, эрх бүхий этгээдийн шийдвэргүй буюу зөвшөөрөлгүй ашигласан нийт 94 зөрчил илэрсэн ба иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэх хуудас хүргүүлэн ажилласан.	100
<b>4.5. Газар зүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжилтын нэгдсэн сан бүрдүүлж, иргэд, байгууллагын хэрэглээнд нэвтрүүлнэ.</b>								
4.5.1.	Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг аймгийн хэмжээнд нэвтрүүлж, газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг олгох ажлыг зохион байгуулах	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	50	60	I-IV улирал	Дорноговь аймгийн хэмжээнд Хаягийн мэдээллийн санд бүртгэсэн гудамж, замын нэрийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан нэртэй тулган шалгасан. Дорноговь аймгийн Мандах, Иххэт сумдад шинээр өмчлөх эрх үүссэн газрын орц гарц, гудамж, замыг зураглан нэршүүлж, харьяалах Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.	100

4.6. Газар зүйн нэрийн тодруулалт хийж мэдээллийн сан бүрдүүлэх, иргэд, байгууллагыг үнэн зөв газар зүйн нэрийн лавлагаа мэдээллээр хангах								
4.6.1.	Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100	100	I-IV улирал	“Тэгшхэм групп” ХХК нь 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Дорноговь аймгийн Засаг Даргын Тамгын Газартай байгуулсан ОНТХО-НТШ-05/2023 дугаартай гэрээг үндэслэн “Дорноговь аймгийн зарим сумдын газар зүйн нэрийн тодруулалт хийх” ажлын хүрээнд 14 сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан байгуулах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнээс газар нутгийн нэрийн зургийн 42-р тогтоолоор батлагдсан албан ёсны 9080 нэрээс Дорноговь аймгийн хэмжээнд нийт 89 нэр олдоогүйгээс гадна нийт 104 худаг устаж дарагдсан бол хээрийн судалгааны явцад 42-р тогтоолын нэрээс зөрсөн 327 тохиолдлыг илрүүлсэн. Мөн Монгол хэлний зөв бичих дүрмийн алдаатай болон ижил гарал үүсэлтэй нэрийг өөр өөр хэрэглэх явдал байгааг илрүүллээ.	100
4.6.2	Аймгийн газар зүйн нэрийн тодруулгын ажлыг ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны 204 дүгээр тушаалаар байгуулагдсан хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийн зөвлөмж, дүгнэлтийн дагуу холбогдох засварыг хийж, Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулах,	-	Аймгийн ИТХ тогтоолын тоо	-	1	II-III улирал	Дорноговь аймгийн 14 сумын “Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил-ын үр дүнд өөрчлөн батлуулах 316 , шинээр тодруулж тогтоосон газар зүйн нэр 404 , Байрлал зөрүүтэй 24 , 1980-1984 оны хээрийн тодруулалтаар 1:100000-ны масштабтай байр зүй зураг дээр тодруулж тэмдэглэсэн боловч УИХ-аар батлагдаагүй газар зүйн нэр 1822 нэрс байна.	100

#### Эх сурвалжийн дэлгэрэнгүй мэдээлэл

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Л.Олзбаяр  
Цахим шуудан: Olzbayar.o@dornogovi.gazar.gov.mn  
Холбоо барих утас: 86038393

#### Эх сурвалжийн дэлгэрэнгүй мэдээлэл

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Ц.Баярмаа  
Цахим шуудан: bayarmaa.ts@gazar.gov.mn  
Холбоо барих утас: 96373557